



**ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН ЧАДЛЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцлийг бүрдүүлсэн байна.” гэж, “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шат болох Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.” гэж, 3.3.1.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.”, 3.3.2.2-т “Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн өнгөрсөн хугацаанд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлын 2 зөвлөмж, Улсын Их Хурлын 6 тогтоол, Засгийн газрын 45 тогтоол, тэмдэглэл зэрэг эрх зүйн баримт бичгүүд батлагдсан.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т хүрсэн бөгөөд тус хэлэлцээрт тусгасан зарим зохицуулалт нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаас өөрөөр заасан.

Иймд энэхүү хэлэлцээр нь Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ”-нд хамаарах бөгөөд Улсын Их Хурал заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага үүсээд байна.

## **1.2. Практик шаардлага**

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг 1955 онд байгуулж, Замын-Үүд-Эрээн боомтыг төмөр замаар холбосноос хойш дахин төмөр замын боомт байгуулагдаагүй байна.

Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, өсөн нэмэгдэх ачаа тээврийн хэрэгцээ, шаардлагыг хангах, тээвэрлэлтийн нөхцлийг сайжруулахын тулд хоёр дахь төмөр замын гарц зайлшгүй шаардлагатай болно.

Монгол Улсын Ерөнхий сайд болон БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд нарын 2009 онд уулзсан уулзалтын үеэр “Тавантолгойн нүүрсний орд газарт хамтран ажиллаж, тэнд олборлосон боловсруулсан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Шиньхуагийн төмөр замыг ашиглан БНХАУ-д болон Ази Номхон далайн бүс нутагт хамтран борлуулах” саналыг тавьснаас хойш “Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замыг хамтран байгуулах” тухай яриа хэлэлцээг талууд эхлүүлсэн байна.

Дээрх яриа хэлэлцээний дагуу 2009 онд байгуулсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, 2013 онд баталсан “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”, 2014 онд байгуулсан “Монгол улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” зэрэг баримт бичгүүдэд эрдэс баялаг, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэхээр тусгасан.

“Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын Санамж бичиг” 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр байгуулагдсан.

Энэхүү санамж бичгийн хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Чайна энерги” ХХК-ийн хооронд Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг байгуулсан бөгөөд тус хэлэлцээрт төмөр замыг холбох бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, хил дамнасан төмөр замын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх хэсгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг “Чайна энерги” ХХК, Монгол Улсын хил доторх хэсгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК нар хариуцах нөхцөлөөр хамтран ажиллахаар тохиролцсон.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 4 удаагийн захирамжаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “1955 оны “Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр” болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд Ажлын хэсэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай давхардсан тоогоор 60 орчим удаа уулзалт, хэлэлцээ хийсэн.

Эдгээр уулзалт, яриа хэлэлцээний үр дүнд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан.

Тус хэлэлцээрт Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулах, хоёр талт урт хугацаанд тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, хоёр талын төрийн өмчит хуулийн этгээд хооронд байгуулах нүүрс худалдах, худалдан авах гэрээг харилцан ашигтай, нийлүүлэлт тогтвортой байх зарчын дагуу байгуулах, нүүрсний орд дахь уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.

#### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулалт, хамрах хүрээ**

Хуулийн төсөлд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай асуудлыг тусгана.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай” агуулгаар боловсруулна.

#### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, ач холбогдол**

Хуулийн төсөл батлагдсанаар ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах, дунд болон

урт хугацааны нүүрс олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж төсвийн орлого, валютын нөөцийг өсгөх, Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордыг иж бүрэн ашиглах, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам баригдаж тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүнийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар тээвэрлэх боломж бүрдэх юм.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн тэргүүн нарын 2014 онд баталсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Тус тунхаглал хэрэгжсэнээр Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бүс нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжих юм.

Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулах ажлыг эхлүүлснээр Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замыг байгуулах нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээр байгуулснаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш, Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдүүлэх, ядуурлын түвшин бууруулж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих боломжийг бүрдүүлэх зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын хууль тогтоомжтой хэрхэн уялдах, шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

-oOo-